



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 7
Утас/Факс: (976-11) 32-71-99,
<http://www.ulaanbaatar.mn>

2017. 11. 15 № 03/3904

танай _____-ны № _____-т


НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАД

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр Албан даалгаврыг нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг хүргүүлж байна.

Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах талаар онцгой анхаарч, биелэлтийг сар бүрийн 05-ны өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ үү.

Хавсралт 5 хуудастай.

ДАРГА



М.ОТГОНБАЯР

111020004823

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

С.БАТБОЛД

2017 оны 11 дүгээр сарын 07

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН "САХИЛГА ХАРИУЦЛАГА, ДЭГ-ЖУРМЫГ
ЧАНГАТГАХ ТУХАЙ" 01 ДҮГЭЭР АЛБАН ДААЛГАВРЫГ НИЙСЛЭЛИЙН
ХЭМЖЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хэрэгжүүлэх байгууллагууд	Хариуцан тайлагнах хэлтэс
Нэг. Сахилга хариуцлага, ёс зүйн чиглэлээр				
1	"Ёс зүй-Сахилга хариуцлага" сургалтыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтнуудад зориулан зохион байгуулах	XI/ 1	НЗДТГазар	НЗДТГазар (ТЗУХ)
2	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтнуудаас ёс зүйн мэдэгдэл гаргуулах ажлыг зохион байгуулах	XI/ 10-ны дотор	Агентлаг, дүүрэг, ОНӨААТҮГ-ын удирдлагууд	НЗДТГазар (ТЗУХ)
3	Байгууллагын "Ёс зүйн дүрэм"-ийг шинэчлэн батлуулах, мөрдүүлэх	Жилдээ	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд	НЗДТГазар (ТЗУХ)
4	Төрийн албан хаагчдыг авлига, ашиг сонирхол, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт, давтан сургалт зохион байгуулах	Жилдээ	Нийслэлийн нутгийн захиргааны болон ОНӨААТҮГазрууд	НЗДТГазар (ТЗУХ)
5	Ёс зүйн зөрчил гаргасан албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах, гарсан шийдвэрийг ил тод мэдээлэх	Тухай бүр	Нийслэлийн нутгийн захиргааны болон ОНӨААТҮГазрууд	НЗДТГазар (ТЗУХ)
6	Нийслэлийн нутгийн захиргааны болон ОНӨААТҮГ-ын албан тушаалтны ёс зүйн зөрчлийн мэдээний нэгдсэн санг бий болгох	XII/ 01-ны дотор	НЗДТГазар	НЗДТГазар (ТЗУХ)
7	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд, ОНӨААТҮГ-ын ажилтнуудын хөдөлмөрийн болон үр дүнгийн гэрээг ажлын гүйцэтгэлтэй уялдуулж үнэлж дүгнэх.	Жилдээ	Нийслэлийн нутгийн захиргааны болон ОНӨААТҮГазрууд	НЗДТГазар (ТЗУХ)
8	Ажилтан албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэх, сахилга хариуцлагыг дээшлүүлэх талаар байгууллага бүр тодорхой ажлыг зохион байгуулж үр дүнг тооцож ажиллах	Тухай бүр	Нийслэлийн нутгийн захиргааны болон ОНӨААТҮГазрууд	НЗДТГазар (ХШҮХ)
9	Иргэдийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд цаг алдалгүй шуурхай зохион байгуулах дадлага эзэмшүүлэх "Өдөр тутмын бэлэн байдал" арга хэмжээг зохион байгуулах	Жилдээ	НЗДТГазар	НЗДТГазар (ЦШтаб)

Хоёр.Төсвийн сахилга батыг сайжруулах чиглэлээр				
1	Төсвийн үргүй зардлыг багасган, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, төсвийн хэмнэлтийн горимд шилжин ажиллах тухай нийслэлийн нутгийн захиргааны болон ОНӨААТҮГ-дад хандсан уриалга гаргах, хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих	XI/ 20-ны дотор	НЗДТГазар	НЗДТГазар (СТСХ)
2	Байгууллагын санхүүгийн анхан шатны баримтын бүрдлийг хангаж нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, УИХ, Засгийн газар, Сангийн сайдын баталсан холбогдох заавар журмыг мөрдөж ажиллах	Тухай бүр	Нийслэлийн нутгийн захиргааны болон ОНӨААТҮГазрууд	НЗДТГазар (СТСХ)
3	Төсвийн хөрөнгө оруулалтын ажлын явц, чанар, үр дүнд хийх хяналт шинжилгээний ажлыг эрчимжүүлэх	XI/ 1-ээс XII/ 20-ны өдөр хүртэл	Нийслэлийн нутгийн захиргааны болон ОНӨААТҮГазрууд	НЗДТГазар (ХШҮХ)
4	Байгууллагын өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, захиран зарцуулалтанд хяналт тавих, дотоод хяналтыг сайжруулах	Тухай бүр	Нийслэлийн нутгийн захиргааны болон ОНӨААТҮГазрууд	НЗДТГазар (СТСХ)
Гурав.Төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр				
1	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, нийслэлийн хэмжээнд өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг богиносгох, зөрчил, дутагдал гаргасан албан тушаалтанд тухай бүр хариуцлага тооцуулан, зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлж ажиллах	Тухай бүр	Нийслэлийн нутгийн захиргааны болон ОНӨААТҮГазрууд	НЗДТГазар (НҮНТөв)
2	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас олгож буй тусгай зөвшөөрлийг хүнд сурталгүй, чирэгдэлгүй олгох үйл ажиллагааг хуульд нийцүүлэн зохион байгуулах, үйлчилгээтэй холбоотой дүрэм журмыг шаардлагатай тохиолдолд сайжруулан өөрчлөх санал оруулах.	Тухай бүр	УБ хотын ЗААлба НБол Газар НЭМГазар НБОГазар НАЖГазар	НЗДТГазар (ХЭЗХ)
3	Яам, Засгийн газрын агентлагаас үзүүлж буй зарим үйлчилгээг НҮНТөвөөр үзүүлдэг болох талаар судалж хамтран ажиллах санал боловсруулах	XII/ 01-ны дотор	НЗДТГазар	НЗДТГазар (ТЗУХ НҮНТөв)
4	НҮНТөвийн үйлчилгээний тоог нэмэгдүүлэх, ажлын цагийн хуваарийг өөрчлөх талаар судалгаа хийж, хэрэгжүүлэх	XII/ 01-ны дотор	НЗДТГазар	НЗДТГазар (ТЗУХ НҮНТөв)
5	Худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд зохион байгуулж, хар жагсаалтад орсон байгууллагуудыг Сангийн яаманд мэдээлж бүртгүүлэх, дахин тендер шалгаруулалтад оролцуулахгүй байх арга хэмжээ авах	Тухай бүр	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд	НХААГ НДотоод Аудитын алба

Дөрөв. Бусад				
1	Албан даалгаврын хэрэгжилтийн мэдээг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас гаргуулж дүнг нэгтгэн ЗГХЭГ-т хүргүүлэх	Жил бүрийн 12 сарын 20-ны дотор	НЗДТГазар	НЗДТГазар (ХШҮХ)
2	НИТХурлын тогтоолд кодификаци хийж, хүчингүй болгох, нэмэлт өөрчлөлт оруулах шийдвэрийн жагсаалт гаргах, хуралд санал оруулах	Жилдээ	Нийслэлийн нутгийн захиргааны болон ОНӨААТҮГазрууд	НЗДТГазар (ХЭЗХ)
3	Албан даалгаврыг хэрэгжүүлж, үр дүнг тайлагнах	Сар бүрийн 05-ны дотор	Нийслэлийн нутгийн захиргааны болон ОНӨААТҮГазрууд	НЗДТГазар (ХШҮХ)
4	Албан даалгавар хэрэгжүүлэх талаар зохион байгуулж буй ажлуудыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах	Тухай бүр	Нийслэлийн нутгийн захиргааны болон ОНӨААТҮГазрууд	НЗДТГазар (ХМОНХХ)

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН АЛБАН ДААЛГАВАР

2017 оны 10 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай

Шударга, ил тод, хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлж, төрийн бүх шатны байгууллагад ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас дараах албан даалгаврыг өгч байна:

1. Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагын дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад:

1.1. Иргэндээ ээлтэй хуулийн засаглалыг бэхжүүлэх: Төрийн бүх шатны байгууллагын албан хаагчид шударга ёс, хууль дээдлэх зарчим баримтлан, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, улс төрөөс ангид, мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ажиллах;

1.2. Авлигын хяналтыг сайжруулах: Төрийн албыг хувийн ашиг сонирхлын хэрэгсэл болгох гэсэн оролдлогыг тухай бүр нь таслан зогсоож, авлига, хээл хахууль, хүнд суртал, шударга бус байдалтай шат шатандаа тууштай тэмцэх;

1.3. Иргэдээ сонсож, төрийн албаны хариуцлагыг өндөржүүлэх: "Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төв"-д иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай нягтлан шалгаж, асуудлыг шийдвэрлэн дутагдал гаргасан холбогдох албан тушаалтанд тухай бүр хариуцлага тооцож ажиллах;

1.4. Төрийн албаны үр ашгийг сайжруулах: Ажилтан, албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэх, ажлын байрны дэг журмыг чанд сахих;

1.5. Бодлогын тогтвортой байдлыг хангах: Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангаж, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх.

2. Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

2.1. Албан тушаалтны сахилга, хариуцлагыг өндөржүүлж, аливаа ажил, асуудлыг цаг алдалгүй шуурхай зохион байгуулж гүйцэтгэлийн явц, үр дүнд тавих хяналтыг сайжруулан хүлээлгэх хариуцлагыг чангатгаж, төрийн албаны стандартыг мөрдүүлж ажиллах;

2.2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, хууль тогтоомжид заасан лиценз болон бусад тусгай зөвшөөрөл, газар олгох ажлыг нийтэд ил тод, нээлттэй болгон зохион байгуулж ажиллах;

2.3. Төрийн албаны тухай хууль тогтоомж, дүрэм, журмыг хэрэгжүүлж, төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах, сайн засаглалыг бэхжүүлэн иргэд, аж ахуйн нэгжид төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хүнд суртал, чирэгдэл, ёс зүйн доголдол гаргахгүй байх;

2.4. Хууль тогтоомж зөрчсөн, зөрчил, дутагдал гаргасан, ажлаа цалгардуулсан албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу тухай бүр нь хариуцлага тооцож, зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлж байх;

2.5. Удирдлага, ажилтнуудын үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэж, гүйцэтгэлийн үр дүнг урамшуулал, хариуцлагатай холбож ажиллах.

3. Төсвийн хөрөнгө оруулалтын ажлын чанар, үр дүнг дээшлүүлж төсвийн үргүй зардлыг багасган хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, хэмнэлтийн горимыг чанд сахин ажиллахыг бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгаж байна.

4. Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын ажлын уялдаа холбоог сайжруулж, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг нэг цэгийн үйлчилгээгээр дамжуулан хуулийн хүрээнд хүртээмжтэй, шуурхай, чирэгдэлгүй зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж байна.

5. Албан даалгаврын хэрэгжилтийг жилийн эцсээр дүгнэж тайлангаа ирүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож байна.

6. Энэхүү албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатарт хариуцуулж байна.

Монгол Улсын Ерөнхий сайд



У.ХҮРЭЛСҮХ